



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 4/296

Улаанбаатар хот

Г Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн
хөтөлбөр сонгох журам батлах тухай

Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


- “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ыг хавсралтаар баталж, 2020 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
- Тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам” батлах тухай А/462 тоот тушаалыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс хүчингүй болгосугай.
- Журмыг сурталчлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн дарга /Н.Пүрэвцогт/, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

3340302811



БАКАЛАВРЫН ТUVШНИЙ ОЮУТНЫ МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СОНГОХ ЖУРАМ

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Их Сургууль (МУИС)-д элсэн суралцсан оюутнуудад бакалаврын зэрэг олгох мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой аливаа асуудлыг зохицуулахад оршино.

1.2. МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуульд элсэж, ерөнхий суурийн болон бүрэлдэхүүн сургуулийн суурийн 24-өөс доошгүй багц цагийн хичээл судалсан оюутан цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрөө хаврын улирлын эцэст сонгоно. Энэхүү багц цагийн нийтлэг шаардлагаас гадна ерөнхий суурийн зарим хичээлийг тухайн хөтөлбөрийн онцлогоос хамааруулан заавал амжилттай судалсан байхыг шаардаж болно. Уг шаардлагыг бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны шийдвэрээр тодорхойлсон байна.

1.3. CR үнэлгээтэй хичээлүүдийн багцыг судалсан багцад оруулан тооцно. Сургалтын мэдээллийн системд оюутны судалсан, F*, NA, NR үсгэн тэмдэглэгээнээс бусад үнэлгээтэй хичээлийн багц цагийг судалсан багц цагт тооцно.

1.4. Хууль зүйн сургууль нэг хөтөлбөрт тул уг хөтөлбөрт элссэн оюутны хөтөлбөр сонголтын тушаалыг намрын улиралд гаргана.

1.5. Мэргэжлийн хөтөлбөр сонголтын шаардлага хангаагүй оюутнууд ерөнхий суурийн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцаж хөтөлбөр сонгох шаардлагыг хангасан улирлын төгсгөлд онооны нэгдсэн жагсаалтад орж хөтөлбөрийн сонголт хийнэ.

1.6. Элсэлтийн Ерөнхий Шалгалт (ЭЕШ) өгч МУИС-д хувийн зардлаар элсэн суралцаж буй гадаад оюутнууд мэргэжлийн хөтөлбөр сонголтыг энэхүү журмын дагуу, сургууль хоорондын гэрээ болон Засгийн газар хоорондын гэрээгээр суралцдаг оюутны хувьд холбогдох эрх зүйн актыг үндэслэн батлагдсан хяналтын тооноос тусад нь хөтөлбөр сонголтыг Хөтөлбөр хариуцсан захиргааны нэгж (ХХЗН)-ээс зохион байгуулж, гүйцэтгэнэ.

1.7. Шинжлэх Ухааны Сургуульд суралцаж байгаа ерөнхий суурийн хөтөлбөрийн оюутнуудын хувьд элсэн орсон салбарын хөтөлбөрүүдээс сонгоно. Шинжлэх ухааны сургуулийн оюутан тухайн салбарын багцаар зарлагдсан хөтөлбөрүүдэд санал өгч, баталгаажуулж болно.

1.8. Шинжлэх Ухааны Сургуулийн Байгалийн ухааны салбарын Багц 2, Багц 3, Хүмүүнлэгийн ухааны салбарын Багц 2-т элссэн оюутнуудын элсэлтийн тушаалыг үндэслэн хөтөлбөр сонголтын тушаалыг намрын улиралд гаргана.

1.9. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцсэн (Журмын 3.1) мэргэжлийн хөтөлбөр бүрээр суралцах оюутны хяналтын

тооны саналыг МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж, захирлын тушаалаар баталгаажуулна.

1.10. Оюутны цаашид үргэлжлүүлэн суралцах мэргэжлийн хөтөлбөрийн жагсаалт, батлагдсан хяналтын тоог 5 дугаар сарын эхний хагаст багтаан МУИС-ийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

1.11. Мэргэжлийн хөтөлбөр сонголтыг 6 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Даваа гарагаас эхлэн ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасны дагуу явуулна.

1.12. Мэргэжлийн хөтөлбөр сонголтын дүнг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, суралцах оюутан, хөтөлбөр сонголтын явцын тухай санал, дүгнэлт гаргана.

1.13. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлын саналыг МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ХХЗН мэргэжлийн хөтөлбөр сонгосон оюутны овог, нэр, бүртгэлийн дугаар, жагсаалтын онооны мэдээллийг хөтөлбөр тус бүрээр гаргаж, МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

1.14. Зарим сонголт багатай хөтөлбөрүүдийн баталгаажуулалтыг цуцлах тухай МУИС-ийн Захиргааны зөвлөлийн шийдвэрийн хүрээнд тухайн хөтөлбөрийг сонгосон оюутны нэмэлт хөтөлбөр сонголтыг оюутны өөрийн саналд үндэслэн хяналтын тоо нь гүйцээгүй хөтөлбөрүүдээс дахин сонгуулна.

1.15. Хөтөлбөр сонголтыг баталгаажуулах тушаал гаргах болон сургалтын мэдээллийн системд оюутны сонгосон хөтөлбөр баталгаажуулах ажлыг дараагийн улирлын хичээл сонголтоос өмнө хийнэ.

1.16. Оюутан ерөнхий суурь хөтөлбөрт хичээлийн 2 жил хүртэлх хугацаанд суралцах ба энэ хугацаанд мэргэжлийн хөтөлбөр сонголтыг заавал хийнэ. 2 жилд багтаан мэргэжлийн хөтөлбөр сонгоогүй бол сургуулиас хасах үндэслэл болно.

1.17. Хөтөлбөр сонгох хугацаа (Журмын 1.11-р заалт) эхлэхээс өмнө хөтөлбөр сонголтоо хойшлуулах хүсэлтээ (Маягт 1) ХХЗН-д бичгээр гарган шийдүүлнэ. Санал өгөх хугацаа эхэлснээс хойш хүсэлтийг хүлээн авахгүй. Хөтөлбөр сонголтоо хойшлуулсан оюутан дараагийн улиралд Ерөнхий суурийн хөтөлбөртөө үргэлжлүүлэн суралцана.

1.18. Оюутан хөтөлбөр сонголтоо хойшлуулсан, сонголтоос хоцорсон, болзол шинээр хангасан тохиолдолд дараагийн намрын улирал эхлэхээс өмнө эсвэл намрын улирлын төгсгөлд хяналтын тоо нь гүйцээгүй хөтөлбөрөөс нэмэлтээр сонгож болно.

1.19. Мэргэжлийн хөтөлбөр сонголт хойшлуулсан шийдвэрийн дагуу оюутныг онооны нэгдсэн жагсаалтаас хасах тэмдэглэлийг хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн сургалтын мэдээллийн системд мэргэжлийн хөтөлбөрт санал өгөх хугацаа эхлэхээс өмнө хийнэ.

1.20. Оюутан хичээлийн жилийн төгсгөлд буюу хаврын улиралд хөтөлбөр сонголт хийж байгаа бол тухайн хичээлийн жилийн баталгаажсан хөтөлбөрийн хяналтын тоонд багтаж хөтөлбөр сонгоно. Харин намрын улирлын эхэнд болон намрын улирлын төгсгөлд нэмэлтээр хөтөлбөр сонгоходоо өмнөх хичээлийн жилийн хяналтын тоо нь гүйцээгүй хөтөлбөрөөс хийнэ.

1.21. Өмнө нь бакалаврын зэрэг эзэмшсэн суралцагч МУИС-д шинээр элсэн суралцах (хоёрдогч бакалавр) үеийн хичээл дүйцүүлэлт 24 багц цагаас доошгүй байгаа тохиолдолд хөтөлбөр сонгох ерөнхий болзол хангасан гэж үзнэ.

- 1.21.1. Болзол хангасан оюутанд МУИС-ийн өмнөх хичээлийн жилийн хяналтын тоо нь гүйцээгүй хөтөлбөрийг санал болгоно.
- 1.21.2. Хэрэв уг хөтөлбөрөөс сонголт хийхгүй гэвэл уг элсэгч нь тухайн элссэн бүрэлдэхүүн сургуулийн 2 хүртэлх тэнхимд хөтөлбөрт шууд элсэх тухай хүсэлт гаргаж болох ба ~~тэнхимийн~~ ~~шилжилтийн~~ шалгалтын комисс шалгалт авч тухайн хүсэлтийг шийдвэрлэнэ. Тэнхимд гаргасан хүсэлтийн дагуу хөтөлбөр сонгох боломжтой гэж шийдвэрлэгдсэн тохиолдолд уг оюутны хөтөлбөрт элсүүлэх тухай МУИС-ийн захирлын тушаал гарч баталгаажна.
- 1.21.3. Тэнхимийн шилжилтийн шалгалтын комисс тухайн оюутныг хөтөлбөрт элсүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд уг оюутан нь Ерөнхий суурийн хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж, журмын үндсэн шаардлагуудын дагуу хөтөлбөр сонголтоо хийнэ.

ХОЁР. Мэргэжил сонгуулах комисс

2.1. МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан мэргэжлийн хөтөлбөр сонгуулах комисс нь мэргэжлийн хөтөлбөр сонгуулах ажлыг зохион байгуулна.

2.2. Комисс нь МУИС-ийн сургалт, оюутан хариуцсан дэд захирал, сургалтын мэдээллийн систем хариуцсан нэгжийн дарга болон ХХЗН-ийн дарга, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нараас бүрдэнэ. Комиссын дарга нь МУИС-ийн сургалт, оюутан хариуцсан дэд захирал, нарийн бичгийн дарга нь ХХЗН-ийн дарга байна.

2.3. Комисс мэргэжил сонгох үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох санал хүсэлтийг шийдвэрлэж, энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина. Түүнчлэн мэргэжлийн хөтөлбөр сонголтын үед гарсан энэ журмаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.4. Суралцагчийн эцэг, эхийн төлөөлөл комиссын албан ёсны зөвшөөрөлтэйгөөр хөндлөнгийн ажиглагчаар оролцож болно. Хөндлөнгийн ажиглагчаар оролцох хүсэлтээ мэргэжлийн хөтөлбөрийн сонголт эхлэхээс долоо хоногийн өмнө комисст бичгээр ирүүлсэн байна.

ГУРАВ. Мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа

3.1. Мэргэжлийн хөтөлбөр сонгуулах үйл ажиллагаа нь нэгдүгээрт хөтөлбөр бүрээр суралцах оюутны хяналтын тоог тогтоох, хоёрдугаарт тогтоосон хяналтын тоонд багтаан мэргэжил сонгуулах гэсэн хоёр үе шаттай байна. Хяналтын тоог тогтоохдоо “Мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоог тогтоох аргачлал”-ыг (цаашид “Аргачлал” гэнэ) баримтална.

3.2. Хөтөлбөр бүрээр суралцуулах оюутны хяналтын тоог дараах дарааллаар тогтооно. Үүнд:

- 3.2.1. Тухайн хичээлийн жилийн намрын улирлын 7-8 дугаар долоо хоногт тандалт авах мэргэжлийн хөтөлбөрүүдийн жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөл баталгаажуулж ХХЗН-ид хүргүүлнэ.
- 3.2.2. Оюутан нэг хичээлийн жилд мэргэжил сонгох тандалтын судалгаанд хоёроос доошгүй удаа оролцож, цаашид суралцахаар төлөвлөж буй 3 (ОУХНУС-ийн хувьд 2) мэргэжлийн хөтөлбөрийн саналыг сургалтын мэдээллийн системээр өгнө. Намрын улирлын мэргэжлийн тандалтын хугацаа нь хаврын улирлын эхний долоо хоногийг дуустал

үргэлжилнэ.

- 3.2.3. ХХЗН нь багшийн А цагийн ачааллаар тооцох бүлгийн тоо (Аргачлалын 4 дэх заалт) болон Оюутны тандалтын дунд үндэслэн гарах бүлгийн тоог (Аргачлалын 6 дахь заалт) хөтөлбөр бүрээр тооцоолж, тэнхимийн хөтөлбөрийн хороонд хүргүүлнэ. Тэнхимийн хөтөлбөрийн хороо мэргэжлийн хичээлийн онцлогоос хамааруулан нь Анги танхим, лабораторийн хүчин чадлаас үүсч болох бүлгийн тоог (Аргачлалын 5 дахь заалт) тооцоолж нэгтгэн, Маягт 2-ын дагуу бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргаанд хүргүүлнэ.
- 3.2.4. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн захиргаа тэнхимийн хөтөлбөрийн хорооны саналыг хянаж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн мэргэжлийн хөтөлбөрүүдийн хяналтын тооны талаарх саналыг, хяналтын тоо тодорхойлсон аргачлалын хамт Маягт 3-ын дагуу 4 дүгээр сарын 20-ний дотор ХХЗН-д хүргүүлнэ.
- 3.2.5. ХХЗН бүрэлдэхүүн/салбар сургуулиас ирүүлсэн хяналтын тооны саналыг хянан нэгтгэж, 4-р сард багтаан Захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

3.3. Мэргэжил сонгуулах үйл ажиллагааг дараах дарааллаар зохион байгуулна. Үүнд:

- 3.3.1. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн тэнхим, ХХЗН-ээс оюутанд мэргэжил сонгохтой холбоотой мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.
- 3.3.2. Сургалтын мэдээллийн системээр оюутны сурлагын голч дүн, цуглуулсан багц цаг, МУИС-д элсэхэд тооцуулсан ЭЕШ-ын оноог 68:27:5 харьцаагаар тооцож, онооны жагсаалтыг дараах томьёогоор гаргана.

$$\text{Оюутны оноо} = \frac{\text{Голч дүн}}{4.0} \times 68 + \frac{\text{Цуглуулсан багц цаг}}{M \times 21 + N} \times 27 + \frac{\text{ЭЕШ оноо}}{800} \times 5$$

Энд M нь МУИС-д суралцсан намар, хаврын үндсэн улирлын тоо, N нь шилжилт, дүйцүүлэлтийн улиралд тооцуулсан багц цаг болон зуны улиралд судалсан багц цагийн хэмжээ. Сурлагын голч дүн бодоход сургалтын журамд заасан CR-aас бусад нэмэлт үсгэн тэмдэглэгээг тооцохгүй. Оюутны амжилттай дүгнэгдсэн хичээлүүдийн багц цагийг цуглуулсан багц цагт тооцно.

- 3.3.3. Мэргэжлийн хөтөлбөр сонголт нь оюутан мэргэжлийн хөтөлбөрт саналаа өгөх, өгсөн саналаа баталгаажуулах гэсэн 2 үе шаттайгаар 6 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Даваа гарагаас Баасан гарагийн хоронд явагдана.
- 3.3.4. Даваа гарагийн 9:00 цагт Оюутны оноо сургалтын мэдээллийн системд гарна. Оюутан өөрийн Оюутны оноо гарсан цагаас Мягмар гарагийн 17:00 цаг хүртэл цаашид суралцах мэргэжлийн хөтөлбөрүүдэд сургалтын мэдээллийн системээр саналаа өгнө.
- 3.3.5. Бүрэлдэхүүн/салбар сургуулиас хамааран мэргэжлийн хөтөлбөрт оюутны өгөх саналын тоо ялгаатай байна. ШУС, ХШУИС, БС, ЭС, ЗС-ийн оюутнууд 4, ОУХНУС 2 мэргэжлийн хөтөлбөрт (Журмын 1.2-т заагдсан ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан) санал өгөх боломжтой.

- 3.3.6. Мягмар гарагийн 18:00 цаг гэхэд мэргэжлийн хөтөлбөр бүрээр санал өгсөн оюутнуудын онооны жагсаалт гарна.
- 3.3.7. Лхагва гарагийн 9:00 цагаас 20:00 цаг хүртэл тухайн хөтөлбөрийн хяналтын тоонд багтсан оюутан сургалтын мэдээллийн системд өөрийн эрхээр орж зөвхөн нэг мэргэжлийн хөтөлбөрөөр саналаа баталгаажуулна.
- 3.3.8. Оюутан суралцах мэргэжлийн хөтөлбөрөө сонгон баталгаажуулахад бусад хөтөлбөрт түүний өгсөн санал хүчингүй болно. Энэ хугацаанд жагсаалтын дагуу хяналтын тоонд нэмж багтсан оюутнууд сонголтоо баталгаажуулах боломжтой.
- 3.3.9. Пүрэв гарагийн 9:00 цагаас 20:00 цаг хүртэл хяналтын тоонд нэмж багтсан оюутнуудын мэргэжил сонголтын баталгаажуулалт үргэлжлэн явагдана.
- 3.3.10. Сургалтын мэдээллийн системээр Пүрэв гарагийн 20:00 цаг хүртэл мэргэжлийн хөтөлбөрөө сонгож чадаагүй оюутан үлдсэн тохиолдолд Баасан гарарт онооны жагсаалтын дагуу үлдсэн мэргэжлийн хөтөлбөрөөс сонгуулах үйл ажиллагааг ХХЗН зохион байгуулна. Энэ үед оюутан хөтөлбөр хариуцсан нэгжээс зарласан өдөр, цагт (оюутны үнэмлэхний хамт) өөрийн биеэр хүрэлцэн ирэх шаардлагатай.
- 3.3.11. Тодорхой хүндэтгэн үзэх шалтгаанаар мэргэжлийн хөтөлбөр сонгох боломжгүй болсон тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан сонгуулах боломжтой бөгөөд энэ талаар урьдчилан ХХЗН-д мэдэгдэнэ (Маягт 4).
- 3.3.12. МУИС-ийн Захирлын тушаалаар хөтөлбөр сонголтыг баталгаажуулснаар оюутан цаашид суралцах хөтөлбөрийн хичээлүүдийг сургалтын мэдээллийн системээр сонгож судлах эрхтэй болно.


ДӨРӨВ. Бусад

- 4.1. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал Бүрэлдэхүүн/салбар сургууль, МУИС-ийн Захиргааны зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

Маягт 1



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ХӨТӨЛБӨР, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХЭЛТЭС
210646 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 47.



МУИС-ийн Хичээлийн 1-р байр, 103 тоот

Факс: / Утас: 7730-7730-1311-1318


МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СОНГОЛТ ХОЙШЛУУЛАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1	Оюутны овог, нэр	
2	Оюутны дугаар	
3	Регистрийн дугаар	Xүйс
4	Бүрэлдэхүүн сургууль	
5	Мэргэжил сонголтоо хойшлуулах болсон шалтгаан	
6	Хүсэлт	Миний бие сарын -р сард МУИС-ийн-ны сургуульд элссэн бөгөөд энэ удаад өөрийн хүсэлтээр мэргэжил сонголтоо хойшлуулахыг хүсэж байна. “Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам”-ын 1.20 дэх заалтын дагуу хөтөлбөр сонгохоо хийнэ гэдгээ ойлгосон болно.
7	Хүсэлт гаргасан оюутны гарын үсэг	
8	Хүсэлт гаргасан огноо	
9	Хүлээж авсан мэргэжилтэн	
10	Хүлээж авсан огноо	

Оюутан та, дараах АНХААРУУЛГЫГ уншиж, танилцана уу.

Оюутан та, мэргэжил сонголтоо хойшлуулах хүсэлт гаргасан тохиолдолд энэ хичээлийн жилийн хяналтын тоо нь гүйцэлгүй үлдсэн хөтөлбөрүүдээс

нэмэлтээр намрын улирал эхлэхээс өмнө эсвэл намрын улирлын төгсгөлд хийнэ. Эсвэл дараагийн хичээлийн жилийн хавар шинэ элсэгчидтэй хамт оноогоор жагсан, шинээр батлагдсан хяналтын тоо бүхий хөтөлбөрүүдээс сонголтоо хийх болно. Энэ үед таны төгсөх хугацаа хойшилно гэдгийг анхаарна уу. Мөн элссэнээс хойш 2 жилд багтаан мэргэжлийн хөтөлбөрөө сонгохгүй бол сургуулиас хасагдах болохыг анхаарна уу. Мөн оюутан та, хүссэн мэргэжлээ сонгож чадаагүй бол, тухайн мэргэжлийг хос, хавсарга мэргэжил байдлаар эзэмших (Сургалтын журмын 3.1) эсвэл хөтөлбөр шилжих (Суралцагч шилжүүлэн суралцуулах журмын 5.1) боломжтой юм.



**Мэргэжлийн хөтөлбөрт суралцах
оюутны хяналтын тоог тогтоох аргачлал**

1. Тэнхимиийн хөтөлбөрийн хороо (тэнхимиийн бүтэцгүй бол бүрэлдэхүүн/салбар сургуулийн хөтөлбөрийн хороо) болон ХХЗН хамтран бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт суралцах оюутны хяналтын тоог тогтооходоо энэхүү аргачлалыг (цаашид “Аргачлал” гэнэ) баримтална.

2. Хяналтын тоог (тухайн хөтөлбөрт суралцах оюутны тоо) тухайн хөтөлбөрийн хичээлүүдийг хариуцан заадаг мэргэжлийн багш нарын А цагийн ноогдол, анги танхим, лабораторийн багтаамж хүрэлцээ, оюутны тандалт судалгааны дүн дээр үндэслэн тогтооно. Үүнд:

- 2.1 Тухайн хөтөлбөрийн хичээлүүдийг хариуцан заадаг мэргэжлийн багш нарын А цагийн ноогдолд үндэслэн санал болгож буй оюутны хяналтын тоог бүлгээр илэрхийлэн гаргах бөгөөд тухайн хөтөлбөрөөр суралцах нэг булгийн оюутны тоо 25-аас доошгүй байна.
- 2.2 Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай тоноглогдсон лаборатори, өрөөний ачаалалд үндэслэн тэнхимиийн лабораторийн хүчин чадлыг бүлгээр илэрхийлэн тогтооно. Лекц, семинарын анги танхимын ачааллыг МУИС-ийн хэмжээнд нэгдсэн байдлаар тооцно.
- 2.3 Оюутны тандалтын нийт дүнг тухайн хөтөлбөрийн нэгдүгээр саналын нийт тоон дээр хоёрдугаар саналын тооны хагасыг нэмж бүлэгт байх оюутны тоонд хуваасны бүхэл утгаар тодорхойлно.
3. Хөтөлбөрийн хяналтын тоо нь А цагийн ачааллаар тооцсон бүлгийн тооны санал (Аргачлалын 2.1 ба 4-р заалт), лабораторийн хүчин чадал (Аргачлалын 2.2 ба 5-р заалт), оюутны тандалтын дүнд (Аргачлалын 2.3 ба 6-р заалт) үндэслэн тооцоолсон дунгүүдийн хамгийн бага утга байна.
4. Хөтөлбөрийн А цагийн ачааллаар тооцох бүлгийн тооны (АБТ) саналыг тогтоох дараалал:
 - 4.1 Тэнхимиийн хөтөлбөрийн хороо багш нараа мэргэжлийн хичээл ордог байдлаас нь хамааруулан аль нэг хөтөлбөртөө харьяалуулна (хөтөлбөрийн багш гэнэ). Нэг хөтөлбөрт харьяалуулан тооцсон багшийг өөр хөтөлбөрт давхардуулан тооцохгүй.
 - 4.2 Хөтөлбөрийн багш нарын А цагийн багтаамж (ХЦБ), уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх А цагийн ачааллыг (ХЦА) ХХЗН тооцоолж, хөтөлбөрийн хяналтын тоог бүлгээр илэрхийлнэ.
 - 4.3 ХЦБ-ийг тооцохдоо хөтөлбөрийн багш нарын албан тушаалын зэрэглэлийн (01 тушаалд үндэслэн) сургалтын багц цагийн (А цаг) нормын нийлбэрийг 40 хувиар нэмэгдүүлж тооцно.
 - 4.4 Хөтөлбөрийн багш нарын А цагийн ачааллыг хариуцаж буй өрөнхий суурь, мэргэжлийн суурь болон өөрийн хөтөлбөрийн мэргэжлийн хичээлийн тоо, магистр, докторын түвшинд заагддаг хичээлийн тоо, бусад хөтөлбөрт заагддаг хичээлийн тоонд үндэслэн дараах

төмьёогоор тооцно. Хэмжих нэгж нь багц цаг байна.

ХЦА=ЕС+МС+МХ+МД+БХ

Үүнд:

ЕС -Ерөнхий суурийн болон бусад хөтөлбөрийн хичээлийн цагийн ачаалал

Тухайн хөтөлбөрийн багш нарын МУИС-ийн ерөнхий суурьт хариуцан заадаг хичээлүүдээс багшийн авах багц цагийн нийт хэмжээ. ЕС-ийн хичээлийг сонгон судлах оюутны тоог өмнөх 2 жилийн дунджаар авах боловч МУИС-ийн нийт элсэлтийн тооноос хамааруулж хувилан өөрчилж болно. Уг сонгон судлах оюутны тоог 75 оюутанд хувааж 5 багц цагаар (1 лекц 3 семинар/лаборатори) үргүүлж багшийн авах багц цагийн хэмжээг тодорхойлно. Бусад хөтөлбөрт заах (өөрийн хөтөлбөрт тусгагдаагүй) бүх төрлийн хичээлийг мөн хамтатган оруулах ба лекц, семинар, лабораторийн бүлгээр хичээллэх цагийг нарийвчлан тооцно.

МС –Мэргэжлийн суурь хичээлийн цагийн ачаалал

Тухайн бүрэлдэхүүн сургуулийн суурьт тавигдсан заавал болон сонгон судлах хичээллээс багшийн авах багц цагийн нийт хэмжээ. Заавал судлах хичээлийг судлах оюутны тоог тухайн бүрэлдэхүүн сургуульд тухайн жилд элссэн оюутны нийт тоогоор, сонгон судлах хичээлийг судлах оюутны тоог өмнөх 2 жилийн сонгосон оюутны бүрэлдэхүүн сургуулийн нийт оюутанд эзлэх хувийг тухайн оны элсэгчдийн тоонд хувилж олно. Мэргэжлийн суурь хичээлийн хувьд 50 оюутанд хувааж 4 багц цагаар (1 лекц 2 семинар/лаборатори) үргүүлж багшийн авах багц цагийн хэмжээг тооцоолно.

МХ –Мэргэжлийн хичээлийн цагийн ачаалал


Тухайн хөтөлбөрт тавигдсан мэргэжлийн хичээлүүдээс багшийн авах нийт багц цагийн хэмжээ. Мэргэжлийн хичээлийг 3, 4-р улирлын ба 5-8-р улирлын гэж хоёр хэсэгт хувааж тооцоолно. 3 болон 4-р улиралд заагдахаар тавигдсан хичээллээс үүсэх багшийн ачааллыг тооцохдоо өмнөх 2 жилийн хөтөлбөр сонгосон оюутны бүрэлдэхүүн сургуулийн нийт оюутанд эзлэх хувийг тухайн оны элсэгчдийн тоонд хувилж гаргасан оюутны тоог 25-д хуваахад гарах бүлгийн урьдчилсан тоог (БУТ) 3 багц цагаар үргүүлнэ. 5-8-р улиралд заагдахаар тавигдсан хичээллээс авах багшийн ачааллыг тухайн хөтөлбөрийн одоогийн 2 ба 3-р түвшний идэвхитэй оюутны тооноос хамааруулан тооцоолно. Нэг түвшинд 1-с дээш бүлгийн оюутан байвал багц цагийг Мэргэжлийн суурь хичээлийн цагийн ачааллыг тооцсонтой адилаар 50 оюутны бүлгээр тооцно.

МД –Магистр, докторын сургалтаас үүсэх ачаалал

Магистр, докторын сургалтаас үүсэх ачааллыг профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багш нарын өмнөх 2 жилийн хугацаанд магистр, докторын түвшинд заасан хичээллээс авсан багц цагийн ачааллын дунджаар тодорхойлно.

БХ- Бусад хөтөлбөрт заагддаг хичээлийн цагийн ачаалал

Багшийн харьяа хөтөлбөрт тусгагдаагүй бусад хөтөлбөрт тусгагдсан мэргэжлийн хичээлийг заахад үүсэх багц цагийн ачаалал. Уг



үзүүлэлтийг тухайн багшийн сүүлийн 2 жилд заасан хичээлийн гүйцэтгэлээс дундажлаж тооцоолно.

- 4.5 ХЦА нь ХЦБ-аас бага тохиолдолд МХ-г тооцоолох үеийн БУТ-г нэмэгдүүлэх замаар үүсгэж болох бүлгийн хамгийн дээд хэмжээг (АБТ) тодорхойлно.
- 4.6 ХЦА нь ХЦБ-аас их тохиолдолд тухайн хөтөлбөрөөр бүлэг үүсгэх боломжгүй боловч хөтөлбөрийн онцлог, эрэлтээс хамааруулан 1 хүртэл бүлэг үүсгэж болно.
- 4.7 Хөтөлбөрийн хяналтын бүлгийн тоог тооцсон жишээ

ШУС-ийн А тэнхим A1 хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг 1 профессор, 2 дэд профессор, 1 ахлах багш, 2 багштай гэж үзье. A1 хөтөлбөрийн цагийн багтаамж болон ачааллын талаарх мэдээлэл болон хэдэн бүлэг оюутанд үйлчлэх боломжтойг тооцоолсныг Хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт. Хөтөлбөрийн хяналтын бүлгийн тоо тооцсон жишээ

Тэнхимиийн нэр	A	
Хөтөлбөрийн нэр	A1	
Хөтөлбөр хариуцсан багш нарын тоо /албан тушаалын ангиллаар/	Профессор-1, дэд профессор-2, ахлах багш-1, багш-2	
Үзүүлэлт	Тооцоолсон үр дүн	Тайлбар
ТЦБ	147	$12 \times 1 + 13 \times 2 + 15 \times 3 + 16 \times 4 = 147$
ЕС	19	Нийт 210 оюутанд ЕС-ийн хичээл ордог гэе. Тэгвэл $210 / 75 * 5 = 15$ багц цаг.
МС	40	Бүрэлдэхүүн сургуулийн (БС) суурьт заавал судлах нэг хичээл заадаг бөгөөд БС энэ хичээлийн жилд нийт 400 оюутан элсүүлсэн гэж үзвэл $400 / 50 * 4 = 32$ багц цаг. Сонгон судлахад бүлэгт 1 хичээл тусгагдсан байдаг бөгөөд өнгөрсөн 2 жилд дунджаар нийт БС-д элсэгчдийн 25 хувь нь судалсан гэж үзвэл энэ хичээлийн жилд элссэн 400 оюутны 25 хувь болох 100 оюутан судална гэж үзнэ. 100 оюутны хувьд $100 / 50 * 4 = 8$ багц цаг. Хөтөлбөрийн багш нарын мэргэжлийн суурьт заах багц цагийн ачаалал нийт $32 + 8 = 40$
МХ	60	Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн нийт 60 багц цагийн хичээлийн 12 нь 3 ба 4-р улиралд заагдахаар тусгагдсан гэж үзье. Мөн өнгөрсөн хичээлийн жилд БС-д элссэн 480 оюутны 24 оюутан буюу 5 хувь нь тухайн хөтөлбөрт элсэж байсан гэж үзье. Тэгвэл энэ хичээлийн жилд элссэн 400 оюутны 5 хувь болох 20 оюутан буюу 1 бүлэг энэ удаа хөтөлбөр сонгон гэж

		үзээд үүнийг нийт хичээлийн багц цагийн хэмжээгээр үржүүлж нэмнэ. 1 бүлэг * 12 багц цаг = 12 багц цаг. 5-8-р улиралд нийт $60-12=48$ багц цагийн хичээл заагдах ба 3 ба 4-р түвшний идэвхитэй оюутнууд тус бурдээ нэг бүлэгтэй гэж үзвэл ачаалал нь 48 багц цаг болно. Иймээс мэргэжлийн хичээлээс авах багшийн ачаалал нийт $12+48=60$ багц цаг болно.
МД	17	Тухайн хөтөлбөрийн багш нараас өнгөрсөн 2 жилийн дунджаар 1 жилд нэг профессор нь 8 багц цаг, нэг дэд профессор нь 6, нэг дэд профессор нь 3 багц цагийн хичээл заасан гэж үзвэл магистр, докторын түвшний цагийн ачаалал нийт $8+6+3=17$ болно.
БХ		Өөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, өөр хөтөлбөрт тусгагдсан мэргэжлийн 1 хичээлийг нэг багш 25 оюутанд заадаг гэж үзвэл 3 (1л+1с) багц цаг.
ТЦА	135	$15+40+60+17+3$
Бүлгийн тоо	2	135<147 тул бүлэг үүсгэх боломжтой. МХ-г тооцоолох үеийн 3 ба 4-р улирлын хичээлээс үүсэх бүлгийн тоог 2 байна гэж нэмэгдүүлж үзвэл тухайн хэсэг нь 2 бүлэг * 12 багц цаг = 24 багц цаг болох буюу нийт ТЦА 147 болно. $147\approx147$ тул хоёр бүлэг үүсгэх боломжтой

5. Анги танхим, лабораторийн хүчин чадлыг дараах аргачлалаар тооцно. Лекц, семинарын анги танхимын ачааллыг МУИС-ийн хэмжээнд нэгдсэн журмаар тооцно. Лаборатори болон зөвхөн мэргэжлийн хичээлд зориулан тоноглогдсон, олон мэргэжлийн хичээл ордог эсвэл олон хөтөлбөрт үйлчилдэг өрөөний ачаалалд үндэслэн тэнхимиийн лабораторийн хүчин чадлыг тогтооно.

- 5.1 Нэг улиралд нэг лабораторийн хүчин чадлыг 8-10 бүлэг гэж үзнэ.
 - 5.2 Тухайн хичээлийн жилд 3, 4-р ангид орох нийт бүлгийн тоог өрөө тус бүрээр тооцоолно.
 - 5.3 Тухайн өрөөний хувьд 20-оос 5.2-т тооцоолсон бүлгийн тоог хасахад шинэ хөтөлбөрүүдэд үйлчлэх хүчин чадал гарна.
 - 5.4 Өрөөний хүчин чадалд үндэслэн хөтөлбөр бүрээр санал болгох бүлгийн тоог тогтооно.
6. Оюутны тандалтын дүнд үндэслэн бүлгийн тоог дараах маягаар тогтооно.
 - 6.1 Оюутны сүүлийн тандалтын нийт дүнг гаргахдаа тухайн хөтөлбөрийг нэгдүгээр сонголтоор сонгосон саналын тоон дээр хоёрдугаар сонголтоор сонгосон саналын тооны хагасыг нэмж бүлэгт (25-30) байх оюутны тоонд хуваасны бүхэл утгаар тодорхойлно.
 - 6.2 Оюутны тандалтын дүн 15-аас цөөн байх тохиолдолд хөтөлбөрийн хяналтын тоог 15 гэж тогтооно.

Маягт 2

Тэнхимийн хөтөлбөрийн хорооны
бөглөх маягт (албан хэрэгцээнд)

1117144746
УХД0072 9104399

Хөтөлбөрийн хяналтын тооны тооцооллын хүснэгт*

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Тэнхимийн нэр	
2	Хөтөлбөрийн нэр	
3	А цагийн ачааллаар үүсэх бүлгийн тооны тооцоо Заалт-4 Хөтөлбөр хариуцсан багш нарын тоо /албан тушаалын ангиллаар/ (ХЦБ) Цагийн ачаалал ХЦА (ЕС+МС+МХ+МД) ЕС МС МХ МД А цагийн ачааллаар тооцсон бүлгийн хамгийн дээд хэмжээ	Заалт 4.3 Заалт 4.4 Заалт 4.5, 4.6
4	Лабораторийн хүчин чадлын тооцоо (бүлгээр) Заалт-5 Өрөө 1 Өрөө 2 Лабораторийн хүчин чадлаас үүсэх бүлгийн тоо	
5	Оюутны тандалтаар үүсэх бүлгийн тоо (оюутны тоо) Заалт 6 Нэгдүгээр саналын тоо Хоёрдугаар саналын тоо Оюутны тандалт (бүлгээр)	Заалт 6.1 6.2
6	Хяналтын бүлгийн санал	Заалт 3 (3,4,5- ийн хамгийн бага нь)

*Маягтын 1,2,3 болон 5-р хэсгийг ХХЗН, 4-р хэсгийг тэнхимийн хөтөлбөрийн
хороо бөглөнө.


ХХЗН-ын мэргэжилтэн..... / /

Огноо:

Тэнхимийн эрхлэгч / /

Огноо:

Маягт 3



Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны

бөглөх маягт (албан хэрэгцээнд)

УХПЛ072 9104399

..... сургуулийн хөтөлбөрүүдийн
хяналтын тооны саналын нэгтгэл

№	Хөтөлбөрийн нэр	Тэнхимийн нэр	Аргачлалын дагуу үүсэх бүлгийн тоо	Оюутны хяналтын тооны шийдвэр	
				Бүлгийн тоогоор	Оюутны тоогоор
1					
2					
3					

..... сургуулийн
захирал / /

Огноо:

Маягт 4



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ХӨТӨЛБӨР, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХЭЛТЭС
210646 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 47.
МУИС-ийн Хичээлийн 1-р байр, 103 тоот
УХД0072 9104399

Факс: / Утас: 7730-7730-1311-1318

МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СОНГОЛТЫГ ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧӨӨР СОНГУУЛАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1	Оюутны овог, нэр	
2	Оюутны дугаар	
3	Регистрийн дугаар	Хүйс
4	Оюутны утасны дугаар	
5	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр	
6	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрацийн дугаар	
7	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн утасны дугаар	
	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр мэргэжлийн хөтөлбөрөө сонгуулах болсон шалтгаан	
8	Хүсэлт	Итгэмжлэгдсэн төлөөлөгч миний бие МУИС-ийн..... сургуулийн оюутан-ны мэргэжлийн хөтөлбөр сонголтыг заасан хугацаанд зөв сонгоно гэдгээ ойлгосон болно.
9	Хүсэлт гаргах хөтөлбөр (ШУС, ХШУИС, БС, ЭС, ЗС-ийн оюутнууд 4 хөтөлбөрт, ОУХНУС-ийн оюутнууд 2 хүртэл хөтөлбөрт санал өгнө)	Хөтөлбөр 1: Хөтөлбөр 2: Хөтөлбөр 3: Хөтөлбөр 4:
10	Оюутны гарын үсэг	
11	Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг	
12	Хүлээж авсан мэргэжилтэн	
13	Огноо	

Оюутны итгэмжлэгдсэн төлөөлөгч та дараах АНХААРУУЛГЫГ уншиж, танилцана уу.

Оюутны итгэмжлэгдсэн төлөөлөгч та, мэргэжил сонголтын хугацаанд оюутныг төлөөлж сонголт хийхдээ буруу сонголт хийсэн тохиолдолд сонголтыг буцаах боломжгүйг анхаарна уу.

Жич: Иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргасан байна.